



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/75/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас:70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Назгүл Утас:99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn</p> <p>“Уужим Алтай Аудит” ХХК-ны аудитор: Х.Айгерим Утас:94911004 Цахим хаяг: aykonkh1005@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
Байхгүй	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсонүгийнжагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал, дүгнэлт


**НОГООННУУР СУМЫН ХҮҮХДИЙН
2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
М.ГҮЛМАЗАТ ТАНАА**

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒᠕ № ᠔59

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд 788.6 сая төгрөгийн, бараа материалын дансанд 12.8 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг зохих журмаар хийгээгүй, санхүүгийн тайланд тусгагдсан үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тооцоо бодож баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь заалт болон оршин байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,534,800.00</u>	<u>27,836,090.00</u>
33	АВЛАГА	5,037,750.00	15,000,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,037,750.00	-
335	Бусад авлага	-	15,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	15,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,497,050.00	12,836,090.00
354	Хангамжийн материал	4,497,050.00	12,836,090.00
35410	Бичиг хэргийн материал	-	44,290.00
35420	Аж ахуйн материал	2,914,500.00	3,087,000.00
35440	Түлш, шатах тослох материал	700,000.00	700,000.00
35460	Хүнсний материал	882,550.00	3,614,800.00
35470	Бусад хангамжийн материал	-	5,390,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>749,593,349.97</u>	<u>752,384,065.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	749,593,349.97	752,384,065.15
392	Биет хөрөнгө	749,593,349.97	748,984,065.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	725,352,260.00	725,352,260.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,089,204.40)	(24,178,408.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,965,226.00	36,535,226.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,293,245.20)	(7,527,957.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,735,345.47	16,125,345.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,528,534.92)	(3,057,069.84)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,168,336.58	7,168,336.58
39215	Хуримтлагдсан элэгдэл	(716,833.56)	(1,433,667.12)
39217	Ном		
393	Биет бус хөрөнгө	-	3,400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		3,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>759,128,149.97</u>	<u>780,220,155.15</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,708,297.00</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,708,297.00	-
413	Өглөг	2,708,297.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,708,297.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>756,419,852.97</u>	<u>780,220,155.15</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	756,419,852.97	780,220,155.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	3,400,000.00
51101	Өмч: - төрийн	-	3,400,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	756,419,852.97	776,820,155.15
51210	Өмнөх үеийн үр дүн	756,419,852.97	756,419,852.97
51220	Тайлант үеийн үр дүн	-	20,400,302.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>759,128,149.97</u>	<u>780,220,155.15</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	394,546,240.00	445,727,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,532,440.00	5,390,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,532,440.00	5,390,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,532,440.00	5,390,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,532,440.00	5,390,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	391,013,800.00	440,337,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	376,126,200.00	427,787,600.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		15,240,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	376,126,200.00	412,547,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,599,000.00	12,345,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,599,000.00	12,345,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,288,600.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,288,600.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	422,898,548.08	425,327,297.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,898,548.08	425,327,297.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,609,948.08	425,327,297.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	313,334,765.00	322,979,553.00
210101	Үндсэн цалин	292,962,155.00	277,609,200.00
210102	Нэмэгдэл	20,372,610.00	27,232,473.00
210105	Гэрээт ажлын хөлс		18,137,880.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,166,845.00	43,287,700.00
210201	Тэтгэврийн даатгал	39,166,845.00	30,461,700.00
210202	Тэтгэмжийн даатгал		3,206,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,565,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал		641,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал		6,413,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,805,616.00	12,296,500.00
210301	Гэрэл, цахилгаан	787,000.00	3,237,000.00
210302	Түлш, халаалт	9,018,616.00	9,059,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,395,034.00	5,079,713.00
210401	Бичиг хэрэг	1,538,880.00	640,410.00
210402	Тээвэр, шатахуун	896,804.00	553,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	546,000.00
210404	Ном, хэвлэл	84,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,515,350.00	3,339,803.00
2105	Нормативт зардал	29,218,570.00	22,473,947.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	412,940.00	
210502	Хоол, хүнс	28,765,630.00	21,969,947.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,000.00	504,000.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	390,600.00

210702	Дотоод албан томилолт	100,000.00	390,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,000.00	250,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,549,118.08	18,569,284.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	921,300.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,627,818.08	18,569,284.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,288,600.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,288,600.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,288,600.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(28,352,308.08)	20,400,302.18
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(28,352,308.08)	20,400,302.18

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
C07	Тайлант үеийн үр дүн		756,419,852.97	756,419,852.97
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	756,419,852.97	756,419,852.97
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	756,419,852.97	756,419,852.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	756,419,852.97	756,419,852.97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	3,400,000.00		3,400,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
D08	Тайлант үеийн үр дүн		20,400,302.18	20,400,302.18
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,400,000.00	776,820,155.15	780,220,155.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>391,013,800.00</u>	<u>425,097,600.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	391,013,800.00	425,097,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	376,126,200.00	412,547,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	376,126,200.00	412,547,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,599,000.00	12,345,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,599,000.00	12,345,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,288,600.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,288,600.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>391,013,800.00</u>	<u>422,377,600.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	391,013,800.00	422,377,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,725,200.00	422,377,600.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	302,665,131.00	320,650,100.00
210101	Үндсэн цалин	276,111,131.00	277,609,200.00
210102	Нэмэгдэл	26,554,000.00	26,650,100.00
210105	Гэрээт ажлын хөлс		16,390,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,928,000.00	43,287,700.00
210201	Тэтгэврийн даатгал	28,801,200.00	30,461,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,031,700.00	3,206,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,425,400.00	2,565,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	606,300.00	641,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,063,400.00	6,413,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,599,000.00	12,295,000.00
210301	Гэрэл, цахилгаан	787,000.00	3,237,000.00
210302	Түлш, халаалт	8,812,000.00	9,058,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,758,100.00	3,321,000.00
210401	Бичиг хэрэг	721,300.00	390,600.00
210402	Тээвэр, шатахуун	888,000.00	555,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	461,000.00
210404	Ном, хэвлэл	84,000.00	87,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,704,800.00	1,826,500.00
2105	Нормативт зардал	27,410,800.00	26,971,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	183,000.00	78,100.00
210502	Хоол, хүнс	26,617,400.00	26,259,100.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	610,400.00	634,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	15,050,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		15,000,000.00
210604	Урсгал засвар		50,000.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	390,600.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	390,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,000.00	396,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,000.00	146,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,224,169.00	14,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,224,169.00	14,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,288,600.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,288,600.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,288,600.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u><u>-</u></u>	<u><u>2,720,000.00</u></u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	2,720,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,720,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,720,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		2,720,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u><u>-</u></u>	<u><u>(2,720,000.00)</u></u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u><u>-</u></u>	<u><u>-</u></u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	424,892,600.0	424,892,600.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	424,892,600.0	424,892,600.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	424,892,600.0	424,892,600.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,650,100.0	320,650,100.0
210101	Үндсэн цалин	277,609,200.0	277,609,200.0
210102	Нэмэгдэл	26,650,100.0	26,650,100.0
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	16,390,800.0	16,390,800.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,287,700.0	43,287,700.0
210201	Тэтгэврийн даатгал	30,461,700.0	30,461,700.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,206,500.0	3,206,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,565,200.0	2,565,200.0
210204	Ажилгүйдлийн даатгал	641,300.0	641,300.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,413,000.0	6,413,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,295,000.0	12,295,000.0
210301	Гэрэл, цахилгаан	3,237,000.0	3,237,000.0
210302	Түлш, халаалт	9,058,000.0	9,058,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,386,000.0	4,386,000.0
210401	Бичиг хэрэг	390,600.0	390,600.0
210402	Тээвэр, шатахуун	555,000.0	555,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	461,000.0	461,000.0
210404	Ном, хэвлэл	87,900.0	87,900.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,891,500.0	2,891,500.0
2105	Нормативт зардал	26,971,900.0	26,971,900.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	78,100.0	78,100.0
210502	Хоол, хүнс	26,259,100.0	26,259,100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	634,700.0	634,700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,050,000.0	15,050,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.0	15,000,000.0
210604	Урсгал засвар	50,000.0	50,000.0
2107	Томилолт, зочны зардал	390,600.0	390,600.0
210702	Дотоод албан томилолт	390,600.0	390,600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	396,500.0	396,500.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	146,500.0	146,500.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.0	250,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,464,800.0	1,464,800.0

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,464,800.0	1,464,800.0
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	424,892,600.0	424,892,600.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	412,547,600.0	412,547,600.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	412,547,600.0	412,547,600.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,345,000.0	12,345,000.0
132001	Орон нутгийн төсвөөс	12,345,000.0	12,345,000.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-
610001	Төсвийн байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37.0	37.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22.0	22.0
620003	Үйлчлэх ажилтан	14.0	14.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	175.0	150.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	175.0	150.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	175.0	150.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	37.0	37.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	23.0	23.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.0	14.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	205,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	205,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	205,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	205,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		205,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	205,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор Х.Айгерим гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Назгүл, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь сургуулийн өмнөх насны хүүхдэд цогц хүмүүжил сургалт явуулах, тэдний авьяас чадварыг нээн илрүүлж, насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр бие даасан байдлыг хангах боломжийг бүрдүүлэхэд оршино.

Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг цэцэрлэгийн түвшинд хэрэгжүүлэх, хүүхдийн нас хөгжлийн онцлогт нийцсэн сургалт үйл ажиллагаа явуулах, бага насны хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд багш, эцэг эх асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн өмнөх оны санхүүгийн баримтуудад шалгалт хийгдээгүй байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжтэй ба эрхлэгчийн тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байна. Тус цэцэрлэгийн

дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар аудитад туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 422.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21.0 сая төгрөгөөр 2.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	5 037.8	15 000.0	9 962.2
Урьдчилгаа			
Бараа материал	4 497.0	12 836.1	8 339.1
Үндсэн хөрөнгө	749 593.3	752 384.0	2 790.7
Нийт хөрөнгө	759 128.1	780 220.1	21 092.0
Өр төлбөр	2 708.3		-2 708.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	759 128.1	780 220.1	238 00.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	759 128.1	780 220.1	21 092.0

Мөнгөн хөрөнгө, урьдчилгааны данс оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 15.0 сая төгрөг болж 9.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1075 тоот захирамжаар төсөвт хийсэн зохицуулалтын дагуу “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулахад шаардлагатай техник хэрэгсэл авахад зориулж багаж, техник хэрэгсэл зардлын төсөвт суусан 15.0 сая төгрөгийг “Чарж” ХХК-ний дансанд хөрөнгө нийлүүлэхээр шилжүүлж, шинээр авлага үүсгэснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 12.8 сая төгрөг болж 8.3 сая төгрөгөөр өссөн нь хүнс, бусад хангамжийн материалын дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Төсвийн хөрөнгөөр 37.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 5.4 сая төгрөгийн материалыг үнэгүй хүлэн авч 34.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 752.4 сая төгрөг болж 2.8 сая төгрөгөөр өссөн нь 2.7 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 15.2 сая төгрөгийн хөрөнгийг үнэгүй хүлээн авч, 3.4 сая төгрөгийн газар эзэмших эрхийг орлогоор бүртгэж, 18.5 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 23.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 20.4 сая төгрөг гарсан, 3.4 сая төгрөгийн газар эзэмших эрхийг орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 445.7 сая төгрөг болж өмнөх оноос 51.2 сая төгрөгөөр буюу 13.0 хувиар өссөн дүнтэй байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого, урсгал санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал 425.3 сая төгрөг болж өмнөх оноос 2.3 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа үйлчилгээний урсгал зардал байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны анх батлагдсан төсөв 437.3 сая төгрөг, тодотгосон төсөв 424.9 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх батлагдсан төсвөөсөө 12.4 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд: цалингийн зардлыг 5.8 сая, нийгмийн даатгалын шимтгэлийг 0.8 сая, хангамж бараа материалыг зардлыг 1.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нормативт зардлыг 3.9 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1075 тоот захирамжаар төсөвт хийсэн зохицуулалтаар эд хогшил, урсгал засварын зардлыг 15.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Ковид-19 өвчний улмаас 2021 онд сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд тогтоогдсон хязгаарлалтын улмаас тус цэцэрлэгийн хоолны зардал төлөвлөснөөс хэмнэлттэй гарах боловч хүнсний материалын үлдэгдлийг нөөцлөн хадгалсантай холбоотой хэмнэгдээгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхэд 424.9 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Нийт зарлагын 412.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 12.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 412.5 сая, орон нутгийн төсвөөс 12.4 сая, нийт 424.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 424.9 сая төгрөгийг зарцуулж, төсөвт буцаан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө байхгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 424.9 сая төгрөг буюу 100.0 хувьтай байна.

Нийт төсвийн 75.5 хувийг цалин, 10.2 хувийг НДШ-ийн зардал, 2.9 хувийг тогтмол зардал, 1.0 хувийг хангамж бараа материалын зардал, 6.4 хувийг норматив зардал, 0.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.7 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас 0.2 сая төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаатай холбоотой онцолсон асуудал байхгүй.

Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлээр 424.9 сая төгрөгийг зарцуулсан ба 399.2 сая төгрөг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардал бөгөөд үлдсэн 25.6 сая төгрөг нь тэвчиж болох зардал байна. Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад тэвчиж болох зардлын 10 хувь буюу 2.5 сая төгрөгийн хэмнэлтийг гаргаж ажиллаагүй, тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2021 онд шилэн дансанд оруулбал зохих нийт 151 мэдээллийн 30 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй ба 119 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тус байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 17.6 сая төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.
- ✓ Авлага үүсгэсэн талаарх 15.0 сая төгрөгийн 1 шийдвэрийг оруулаагүй байна.
- ✓ Таван сая төгрөгөөс дээш зарлагын 15.0 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.
- ✓ 5 сая төгрөгөөс дээш цалингийн зардлаас бусад орлогын 25 мэдээллийн 1-ийг хугацаандаа оруулж, 24 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Хугацаандаа мэдээлсэн боловч тайлант оны бүх саруудад 392.8 сая төгрөгийн санхүүжилтийн дүнг хоосон мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгээр 440.4 сая төгрөгийн албан шаардлага өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой 13.4 сая төгрөгийн төлбөрийн 3 акт тогтоож, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналт, шилэн данс, хөрөнгийн тооллоготой холбоотой 824.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна.

Биелэлтийг давтан шалгаж үзэхэд өмнөх оны авлага, өглөгтэй холбоотой зөрчлийг арилгасан боловч шинээр авлага үүсгэсэн, шилэн данс, хөрөнгийн тооллоготой холбоотой зөрчил давтагдан гарсан байна. Төлбөрийн актаас 10.6 сая төгрөгийг барагдуулсан байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд байршуулаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар тус хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн ажил, гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл, зардлын дансны бичилт, нярвын бараа материалын тайлангийн бүрдүүлэлт болон төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа

материалын зарцуулалтад хяналт тавих, эд хөрөнгийн тооллогын тооцоо бодолтод анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 530.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 515.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, 14.7 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 515.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1.Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/10 дугаар тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг байгуулсан байна. Санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд **788.6** /Зөрчлийн дүнг барилга, биет бус хөрөнгөөс бусад хөрөнгийн дүнгээр авав/ сая төгрөгийн, бараа материалын дансанд **12.8** сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг зохих журмаар хийгээгүй, санхүүгийн тайланд тусгагдсан үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тооцоо бодож баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-т “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, 1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-ээс 31-ний дотор/, 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/ гэсэн заалтуудтай нийцэхгүй, оршин байх, толилуулга зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна..

2. Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлээр 424.9 сая төгрөгийг зарцуулсан ба 399.2 сая төгрөг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардал бөгөөд үлдсэн 25.6 сая төгрөг нь тэвчиж болох зардал байна. Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад тэвчиж болох зардлын 10 хувь буюу **2.5** сая төгрөгийн хэмнэлтийг гаргаж ажиллаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д “*үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй*

шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3. Шилэн дансанд санхүүжилтийн 392.8 сая төгрөгийн 25 мэдээллийг 0 дүнтэйгээр мэдээлсэн, 11 сарын мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17.6 сая төгрөгийн зарлагын мэдээллийг огт мэдээлээгүй, 15.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай шийдвэрийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 15.0 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй зэргээр нийт **440.4** сая төгрөгийн зөрчил гаргасан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 25.0 хувьтай байна. Өмнөх аудитаар шилэн данстай холбоотой зөвлөмж өгөгдсөн боловч зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.3-д “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 10.5 сая төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, санхүүгийн тайлангаарх бараа материалын үлдэгдлийг нярвын бараа материалын тайлангийн үлдэгдэлтэй тулгахад 4.2 сая төгрөгийн зөрүүтэй, бараа материалын тайлангийн зарлагын гүйлгээний анхан шатны баримтуудыг дутуу бүрдүүлсэн, зардлын нотлох баримтууд хангалтгүй байх зэрэг нийт **14.7** сая төгрөгийн зөрчил гаргасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5, 20.1.1, 20.1.3, 20.1.4, 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	5	530.2					3	515.5	1	14.7